



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.09.04 № 587

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянтүмэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Ч.Чин-Оргилын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч 211663250576 иргэний бүртгэлийн дугаартай Чингисболд овогтой Чин-Оргилын Баянтүмэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


Бие даан нэр дэвшигч Ч.Чин-Оргилын мөрийн хөтөлбөр **.б..** хуудас хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч "Ч.Чин-Оргил"-д

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт **.б..** хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**ДОРНОД АЙМГИЙН БАЯН ГҮМЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг "Алсын хараа-2050", Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, "Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт", Дорнод аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тулгуурлан нам, иргэний нийгмийн байгууллагууд иргэд, олон нийгмийн саналуудад үндэслэн 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалж, засаглалыг сайжруулах замаар сумыг хөгжүүлэх, Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлсэн бодлогын залгамж чанарыг хадгалж дараах дөрвөн багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаа дэвшүүллээ.

Баянтүэн сум нь 2024-2028 онд эрүүл, идэвхтэй, орлоготой иргэн, өрхийг дэмжин хөгжсөн иргэнтэй сум болох зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Эрүүл, идэвхтэй иргэнийг бодлогоор дэмжинэ.

1. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах, үндэсний бахархал, уламжлалт өв соёлоо дээдлэх, иргэдийг соён гэгээрүүлэх, орлоготой иргэнийг бий болгох, боловсролын хамран сургалт, чанарыг нэмэгдүүлнэ.

1.1. Эрүүл мэндийн чиглэлээр:

1.1.1.1. Эрүүл мэндийн салбарт орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

1.1.1.2. "Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр"-ийн хүрээнд эрүүл мэндийн салбарын зорилтыг хэрэгжүүлэхэд "Эрүүл идэвхтэй амьдрал", "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Хавдрын эсрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулна.

1.1.1.3. Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын нийгмийн хамгааллыг дэмжин, нэн шаардлагатай мэргэжлээр эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэн чадавхижуулж, орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллахад нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

1.1.1.4. Сумын хэмжээнд амны хөндийн өвчлөлийг бууруулах хөтөлбөрийг үргэлжлүүлэн зохион байгуулна.

1.2.1.1. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

1.2.1.2. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.1.3. Хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.2.1.4. Өрхийн бизнес болон жижиг дунд үйлдвэрийг жижиг зээл төсөл, хөтөлбөрт хамруулах бодлого барьж үйлдвэрлэгч сум хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны хөдөлмөр эрхлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

1.3. Боловсролын чиглэлээр:

1.3.1.1. Сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь боловсролын насны хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулна.

1.3.1.2. Багш нарын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлж, боловсролын салбарын

У. Чин-Орш

хөгжлийг дэмжих "Эрдэм" дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

1.3.1.3. Боловсролын салбарт дутагдалтай мэргэжлээр гадаад дотоодын их дээд сургуулиудад оюутан сургах, багш бэлтгэх ажлыг судалгаанд үндэслэн зохион байгуулж тэтгэлэгт хамруулна. /бага ангийн багш, сургуулийн өмнөх боловсролын багш, байгалийн ухааны багш, хөгжмийн боловсролын багш/.

1.3.1.4. Сургуулийн спорт заалыг үргэлжүүлэн барьж ашиглалтад оруулна

1.3.1.5. Сургалтын орчныг сайжруулах зорилгоор сургуулийн байранд их засварыг хийнэ.

1.3.1.6. Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийг дэмжих зорилгоор "Хүн болох багаасаа" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүүхэд бүрд эх орон, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, бахархах, ахмад үе, аав ээж, анд нөхдөө хүндэтгэх төлөвшил дадлыг олгоно

1.3.1.7. Улс, бүс, аймгийн чанартай олимпиад, спорт, урлагийн тэмцээн, уралдаанд амжилт үзүүлсэн иргэнийг урамшуулах тогтолцоог үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.4. Соёл урлагийн чиглэлээр:

1.4.1.1. "Өв соёл" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.4.1.2. "Уламжлалт боловсрол" төслийн хүрээнд шавь сургалтыг зохион байгуулна.

1.5. Биеийн тамир, спортын чиглэлээр:

1.5.1. Нийтийн биеийн тамир, багийн спортоор хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлнэ

1.5.2. "Үндэсний бөх хөтөлбөр", "Монгол нум сум хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.5.3. Тэшүүр, шайбтай хоккей, цана зэрэг өвлийн спортоор хичээллэх талбайтай болно.

1.6. Гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгаалал:

1.6.1. Хөгжих, хамгаалуулах, нийгмийн суурь үйлчилгээг хүүхэд нэг бүрт гэнэ хүртээмжтэй хүргэдэг "Хүүхдэд ээлтэй байгууллага" болох хөдөлгөөнийг өрнүүлнэ.

1.6.2. Өрх бүрийг "Угийн бичиг"-ээ хөтөлж, удмын түүх, ургийн хэлхээгээ өвлөн уламжлах соёлд хэвшүүлнэ.

1.6.4. Хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн бус байгууллага, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

1.6.5. "Гэр бүлийн хөгжил дэвшил" дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

1.7. Залуучуудыг дэмжих чиглэлээр:

1.7.1. Сумын "Залуучуудын хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

1.7.2. Өсвөр үе, оюутан залуус, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө, суралцагчдад мэргэжлээ сонгох, ирээдүйгээ төлөвлөхөд нь зөвлөн туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэмэгдүүлнэ.

1.7.3. Залууст бизнесээ эхлэх, өргөтгөх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх аймгийн "Start up" төвөөр дамжуулан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.7.4. Залуучуудыг нийгмийн оролцоог нэмэгдүүлж залуус сан байгуулахыг дэмжинэ.

1.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр:

1.8.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудаар дамжуулан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хүргэнэ.

1.8.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

1.8.3. Төрийн байгууллага аж ахуйн нэгжийн орчны тохижилтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байхаар тохижуулж тэднийг нийгмийн харилцаанд бусадтай адил тэгш оролцох боломжийг хангана.

1.9. Ахмад настны халамж, үйлчилгээний чиглэлээр:

Ц. Чин Оюун

- 1.9.1. Ахмад настны хөгжил хамгааллын дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.9.2. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зөвлөх үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.9.3. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн болон нөхөн сэргээх эмчилгээг нэмэгдүүлж, хүртээмжтэй байдлыг бий болгоно.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2. Эдийн засгийн эрсдэлийг даван туулж, төсвийг тогтвортой, биеэ даасан бодлого баримтална.

2.1. Санхүүгийн чиглэлээр:

- 2.1.1. Төсвийн сахилга батыг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлж, төсвийн харилцааг бүх шатанд ил тод, нээлттэй байх зарчмыг сайжруулах зорилгоор шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 2.1.2. Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, өмчийн бүртгэл мэдээллийг цахимжуулан орон нутгийн өмчийн хяналтыг сайжруулна.

2.2. Хөдөө аж ахуйн чиглэлээр:

- 2.2.1. Бэлчээрийг усжуулах, худаг гаргах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тооноос чанарт шилжүүлж, малын генийн санг хамгаалах, эрчимжсэн мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.
- 2.2.2. Бүх багуудад ундны усны худаг гаргах, малчдын санал, хүсэлт, иргэдийн оролцоонд тулгуурлан гүний худгийг гаргах бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.
- 2.2.3. Байгалийн нөхөн сэргээгдэх баялаг болох өвс, тэжээл бэлтгэлийг технологийн дагуу нэмэгдүүлж, малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн бүтээгдэхүүнээ аймаг, сумын хэрэгцээнд нийлүүлнэ.
- 2.2.4. Малын үүлдэр угсааг сайжруулж, фермерийн аж ахуйг бодлогоор дэмжинэ.
- 2.2.5. Малын арьс, шир элдэх түүгээр анхан шатны боловруулалт хийх цех үйлдвэр байгуулахыг дэмжинэ.
- 2.2.6. Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах цех байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.7. Үхэр дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.2.8. Залуу малчид болон төрийн албан хаагчдыг малжуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.2.9. Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга, г.м), цар тахал гоц халдварт өвчний тархалт судалгааг тогтмол явуулж, эрсдлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 2.2.10. Мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах зорилгоор сумын өвс тэжээлийн шовулгийн нөөц бүрдүүлж, баг бүрт өвс тэжээлийн агуулахтай болгох ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 2.2.11. Хөдөө аж ахуйн хоршоо, фермерийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлнэ.
- 2.2.12. Газар тариалан, тэжээлийн үйлдвэр барихыг бодлогоор дэмжинэ.

2.3. Мал эмнэлгийн чиглэлээр:

- 2.3.1. Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулна.
- 2.3.2. Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний мөшгөх цахим тогтолцоог хөгжүүлнэ.
- 2.3.3. Гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллана.
- 2.3.4. Халдваргүй өвчний оношлогооны чадамжийг нэмэгдүүлэх, эрт оношилж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.
- 2.3.5. Баянтүмэн сумын мал эмнэлгийн тасаг болон хувийн мал эмнэлгүүдийн чадавхийг сайжруулж, суманд мал эмнэлгийн нэгдсэн төвийг үргэлжлүүлэн бодлогоор дэмжин ажиллана.

У. Чингис-Орш

2.4. Бэлчээрийн чиглэлээр:

2.4.1. Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөц газрын хэмжээг нэмэгдүүлнэ.

2.4.2. Бэлчээрийн даац, доройтлыг нарийвчлан тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлнэ.

2.5. Газар тариалангийн чиглэлээр:

2.5.1. Үр тариа, жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлж, тариалах газрыг хуулийн хүрээнд эзэмшүүлэх бодлого баримтлана.

2.5.2. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж нарийн ногоо боловсруулан савлах, талх, нарийн боовны цех болон гахай, тахианы аж ахуйг хөгжүүлнэ.

2.5.3. "Хүнсний ногоо" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүлэмж, зоорийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.6. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр:

2.6.1. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг сан, төрийн бус байгууллагуудтай хамтран аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажиллана.

2.6.2. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг байгуулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд дэмжиж ажиллана.

2.6.3. Стандартын шаардлагад нийцсэн мал нядалгааны төвийг байгуулж, орчины эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийн хангаж ажиллана.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН

3. Байгалийн болон түүх, соёлын нөөцөд тулгуурлан дотоод, гадаад аялал жуулчлал, дагалдах үйлчилгээний салбар, дэд бүтцийг хөгжүүлнэ.

3.1. Аялал жуулчлалын чиглэлээр:

3.1.1. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэхэд Олон Улсын байгууллага, төсөл хөтөлбөр, бусад байгууллагуудтай хамтарч ажиллана.

3.1.2. Хоёр мэлхийтийн нуурыг сэргээх төсөл хэрэгжүүлж, аялал жуулчлал хөгжүүлнэ.

3.1.3. Байгаль, түүх, соёлын үзмэр, аяллын бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулан нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлнэ.

3.1.4. Орон нутгийн түүхэн болон аялал жуулчлалын газруудын солбицлыг тогтоож кадастрын зураг хийнэ.

3.1.5. Шаазан нуурыг түшиглэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлнэ.

3.2. Уул уурхайн чиглэлээр:

3.2.1. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

3.2.2. Сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын орд ашиглалт, хайгуулын ажил хийж буй ААН, компаниудтай хамтран ажиллах төлөвлөгөөг шинэчлэн баталж сумын иргэдийн зөвлөлийг шинэчлэн байгуулах замаар ил тод нээлттэй ажиллана.

3.2.3. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газруудын судалгааг хийж орхигдсон талбайг нөхөн сэргээнэ.

3.3. Газар зохион байгуулалтын чиглэлээр:

3.3.1. Сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг хийнэ.

3.3.2. Газрын нэгдмэл сангийн ангиллын хот суурин, бэлчээр, хадлан, тариалангийн газарт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хийх ажлыг хэрэгжүүлнэ.

3.3.3. Газрын цахим биржийн үйл ажиллагааг тогтмолжуулж, иргэдэд газар, үл хөдлөх эд

М. Чинзориг

хөрөнгийн нэгдсэн мэдээллийг нээлттэй хүргэх ажлыг зохион байгуулна.

3.4. Дэд бүтцийн чиглэлээр:

- 3.4.1. Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг шат дараалалтайгаар үргэлжлүүлэн шинэчилнэ.
- 3.4.2. Сумын нэгдсэн халаалттай болгоно.
- 3.4.3. Засаг даргын Тамгын газрын барилга шинээр барина.
- 3.4.4. Хөдөөгийн багуудын үүрэн холбооны сүлжээг сайжруулна.

3.5. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

- 3.5.1. Мод тарих хөдөлгөөнийг байнгын, сайн дурын хөлбэрүүдээр өрнүүлэн, урамшуулж, ногоон байгууламжийн тоо, хэмжээг нэмэгдүүлнэ.
- 3.5.2. Жимс жимсгэнэ, гоёлын мод, зүлэг ногоон байгууламжийг дэмжих зорилгоор мод үржүүлгийг дэмжиж ажиллана.
- 3.5.3. "Байгальд ээлтэй иргэн, малчин" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 3.5.4. "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.5.5. Рашаан, булаг, шандны эхийг хамгаалах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, жилд 4-өөс доошгүй булаг, шанд, рашааны эхийг тохижуулж хамгаалах ажлыг хийнэ.
- 3.5.6. Ариун цэврийн байгууламж /нүхэн жорлон/-ийн эрүүл ахуйг сайжруулах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ЭКО ариун цэврийн байгууламжийг бий болгох ажлыг хэрэгжүүлнэ.

3.6. Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр:

- 3.6.1. Иргэдийн экологийн боловсрол, хүмүүжил, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хогийг эх үүсвэрт нь ангилан ялгах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.6.2. Хог хаягдлын менежментийг сумын төвийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хүчин чадалд уялдуулан боловсруулж байгальд ээлтэйгээр шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4. Бүх шатны төрийн байгууллагын чадавхийг бэхжүүлж, төрийн албан хаагчдын сахилга, харицлагыг өндөржүүлэн, иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй хүргэнэ.

4.1. Төрийн үйлчилгээний хүрээнд:

- 4.1.1. Төрийн байгууллагуудын албан хаагчдын ажлын ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулна.
- 4.1.2. "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ий үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 4.1.3. "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 4.1.4. Иргэдэд мэдээлэл олгох "БАГИЙН ӨДӨРЛӨГ", ИРГЭДТЭЙ УУЛЗАХ НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ" зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

4.2. Төрийн албаны чиглэлээр:

- 4.2.1. Мэргэшсэн, чадварлаг албан хаагчдыг бэлтгэн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадавхийг дээшлүүлнэ.
- 4.2.2. Орон нутгийн мэргэжил олгох сургуулиудыг түшиглэн төрийн албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 4.2.3. "Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 4.2.4. Төрөөс баримталж буй авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл

У. Чинзориг

ажиллагааны талаарх бодлого, шийдвэрийг орон нутгийн хэмжээнд шуурхай зохион байгуулж ажиллана.

4.2.5. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын багш, ажилчдыг тогтвортой суурьшилтай ажиллаж, амьдрахад орон нутгаас дэмжих бодлого баримтална.

4.3. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангах чиглэлээр:

4.4.1 Хуулийн хэрэгжилтийг хангуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, нутгийн захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.4.2 "Архигүй дорнодчуудын төлөө" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.4.3 Зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллана.

4.4.4 "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг дэмжиж ажиллана.

4.4.5 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд сэтгэл зүйч ажиллуулна.

4.4.6 Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

4.4.7 Хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.4.8 Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн хэсгийн үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.4.9 Галт зэвсэгт, дэсэрч дэлбэрэх бодисыг олж илрүүлэх, аюулгүй болгох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллана.

4.4. Гамшгаас хамгаалах чиглэлээр:

4.4.1. Гамшгаас хамгаалах багаж тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэн засварлах, иргэдэд гамшгаас хамгаалах талаар сургалт сурталчилгааг зохион байгуулна.

4.4.2. Болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, онцгой нөхцөлийн үед шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, нөөцийг бүрдүүлж, нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

4.5. Батлан хамгаалах чиглэлээр:

4.5.1. Хугацаат цэргийн алба хаах иргэдэд Цэрэг-Эх оронч үзлийг төлөвшүүлж, эрүүл мэндийг сайжруулах чиглэлд санаачилгатай ажиллаж, хугацаат цэргийн алба хаагч иргэдийн хувийг нэмэгдүүлнэ.

4.5.2. Хүүхэд залуучуудад эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэх, Монгол төр ёсны эрхэм үнэт зүйлсийг хамгаалах бэхжүүлэх үнэ цэнийг нь ухамсарлуулах, түгээн дэлгэрүүлж ажиллана.

---oOo---

М. Цеев-Орш